



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/86

Ховд

Орчны бохирдлыг бууруулах
зарим арга хэмжээний тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.4, 11.1.5 дахь заалт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын "Шатахуун түгээх станцаас үүдэлтэй хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг эрчимжүүлэх тухай 07 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Агаар, орчны бохирдлоос сэргийлэх, бууруулах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд үйлчилгээ үзүүлж байгаа шатахуун түгээх станцын гадна байрлах модон жорлонг буулгаж орчны бохирдлоос сэргийлэх, орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан ариун цэврийн хэсэгтэй болгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Нэргүй)-д, шинээр баригдаж буй ашиглалтад орох шатахуун түгээх зориулалттай барилгын загвар зурагт нийцсэн ариун цэврийн хэсгийг тусгуулж ажиллахыг аймгийн ерөнхий архитектор (Б.Түмэндэмбэрэл)-д даалгасугай.

2. Ажлын явц, үр дүнг сар бүрийн 15-ны дотор гаргаж, үр дүнг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Нэргүй)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Э.УРТНАСАН